



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/1290

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл бүртгэн
авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.2.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэн нийлүүлэгдсэн нийт 114,900,000.00 (нэг зуун арван дөрвөн сая есөн зуун мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2. Хавсралтад заасан тээврийн хэрэгслийг бүртгэн авч, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг Хан-Уул дүүргийн 3-р хороо “Энхтитэм” өрхийн эрүүл мэндийн төв (Д.Наранцэцэг)-д, 4 дүгээр хороо “Цэц-до” өрхийн эрүүл мэндийн төв (Х.Бахытжан)-д, 7 дугаар хороо “Хашчагнуур” өрхийн эрүүл мэндийн төв (У.Оюунцэцэг)-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110205607

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
11 сарын 04 өдрийн
№ 1290 дугаар захирамжийн
хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭН АВАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Марк	Арлын дугаар	Улсын дугаар	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Эх үүсвэр	Эзэмшигч байгууллагын нэр
1	Суудлын автомашин	Toyota. Prius Alpha-HW	ZVW413220906	64-17 УБС	2012	2023	38,300,000.0	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан	Хан-Уул дүүрэг 3-р хороо Энхтитэм өрхийн эрүүл мэндийн төв
2	Суудлын автомашин	Toyota. Prius Alpha-HW	ZVW413156894	11-03 УЕС	2011	2023	38,300,000.0	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан	Хан-Уул дүүрэг 4-р хороо Цэц-до өрхийн эрүүл мэндийн төв
3	Суудлын автомашин	Toyota. Prius Alpha-HW	ZVW413024956	21-03 УЕС	2011	2023	38,300,000.0	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан	Хан-Уул дүүрэг 7-р хороо Хашчагнуур өрхийн эрүүл мэндийн төв
Нийт дүн							114,900,000.00		